



ЗАМЫН-ҮҮД ЧӨЛӨӨТ БУСИЙН
ЗАХИРАГЧИЙН ЗАХИРАМЖ

2025 оны 03 сарын 18 өдөр

Дугаар A/13

Улаанбаатар хот

Хөрөнгө оруулалтын гэрээ байгуулах
заавар, гэрээний загвар батлах тухай

Чөлөөт бусийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.6, 8.7.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. "Хөрөнгө оруулалтын гэрээ байгуулах заавар"-ыг нэгдүгээр, "Хөрөнгө оруулалтын гэрээний загвар"-ыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.
2. Энэхүү захирамж батлагдсантай холбогдуулан "Замын-Үүд" чөлөөт бусийн Захирагчийн "Хөрөнгө оруулалтын гэрээ байгуулах заавар, гэрээний загвар батлах тухай" 2016 оны 01 дүгээр сарын 27-ний өдрийн A/06 дугаар захирамжийг хүчингүй болгосугай.
3. "Хөрөнгө оруулалтын гэрээний загвар" шинэчлэн батлагдсантай холбогдуулан хөрөнгө оруулалтын гэрээг үйл ажиллагаагаа эхлүүлсэн иргэн, аж ахуйн нэгжүүдтэй байгуулж, хяналт тавьж ажиллахыг Захирагчийн ажлын албаны дарга (Ш.Амартувшин)-нд даалгасугай.

ЗАХИРАГЧ

Д.ДАМДИНЦЭРЭН



00250053

“Замын-Үүд” чөлөөт бүсийн Захирагчийн
2025 оны 03 дугаар сарын 01-ны өдрийн
A18 тоот захирамжийн 1 дүгээр хавсралт

УХА0373

СИДАМ 1510 0525

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ГЭРЭЭ БАЙГУУЛАХ ЗААВАР

Нэг. Зорилго

1.1. Энэхүү зааврын зорилго нь Чөлөөт бүсийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах, “Замын-Үүд” чөлөөт бүсэд үйл ажиллагаа явуулахаар газар ашиглах эрх авсан иргэн, хуулийн этгээд, Захирагчийн ажлын алба хоорондын эрх, үүрэг, хариуцлага, тус зааврын хүрээнд хамтран ажиллах гэрээ байгуулах, дүгнэх, сунгахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

Хоёр. Нийтлэг үндэслэл

2.1. Чөлөөт бүсийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.5.1 дэх заалтыг хэрэгжүүлэхэд чөлөөт бүсийн асуудал эрхэлсэн төрийн захирагааны байгууллага болон хуулийн этгээдийн бүртгэл хийгдэж, газар ашиглах гэрчилгээ авсан иргэн, хуулийн этгээд хооронд хөрөнгө оруулалтын гэрээ (цаашид “гэрээ” гэх) байгуулахад энэхүү зааврыг дагаж мөрднө.

2.2. Чөлөөт бүсийн тухай хууль, Газрын тухай хууль, Иргэний хууль, бусад холбогдох хууль тогтоомж болон энэхүү зааварт нийцүүлэн нэг талаас чөлөөт бүсийн Захирагчийн ажлын алба, нөгөө талаас чөлөөт бүсэд үйл ажиллагаа явуулахаар хуулийн этгээдийн бүртгэл, газар ашиглах гэрчилгээ авсан иргэн, хуулийн этгээдтэй харилцан тохиролцож байгуулна.

2.3. Гэрээг Захирагчийн захирамжаар баталсан “Хөрөнгө оруулалтын гэрээний загвар”-ын дагуу байгуулна.

Гурав. Хөрөнгө оруулалтын гэрээ байгуулах иргэн, хуулийн этгээдийн эрх, үүрэг

3.1. Чөлөөт бүсэд үйл ажиллагаа явуулах газрын дуудлага худалдаанаас газар ашиглах эрх авсан, хөрөнгө оруулагч иргэн, хуулийн этгээд нь Чөлөөт бүсийн тухай хууль болон энэхүү зааврын дагуу гэрээ байгуулах хүсэлтээ Захирагчид албан бичгээр гаргана.

3.2. Энэхүү зааврын 3.1-д заасан гэрээ байгуулах хүсэлтэд дор дурдсан баримт бичгийг хавсаргасан байна:

3.2.1. Хүсэлт гаргагч хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээ болон хуульд заасан тохиолдолд эрх бүхий байгууллагаас олгосон тусгай зөвшөөрөл, бусад эрхийн гэрчилгээний хуулбарыг тус тус;

3.2.2. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ, газрын төлөв байдал, чанарын хянан баталгаа, архитектур төлөвлөлтийн даалгавар, зураг төслийн гэрээ, Дорноговь аймгийн Ерөнхий архитектораар батлуулсан эх загвар зураг, инженер геологийн дүгнэлт, техникийн нөхцөл, барилга байгууламжийн ажлын зураг, барилгын ажил эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрөл;

3.2.3. Захирагчийн захирамжаар баталсан гэрээний загварын дагуу байгуулах гэрээний төсөл;

3.2.4. Үйлдвэрлэл үйлчилгээ эхлэхийн өмнө болон төсөл бүрэн хүчин чадлаараа хэрэгжиж эхлэх хүртэлх үе шатны хөрөнгө оруулалтын ажлын хуваарийг Захирагчийн ажлын албанад ирүүлнэ.

Дөрөв. Захирагч, түүний ажлын албаны эрх, үүрэг

4.1. Захирагч, түүний ажлын алба энэхүү зааврын 3.2-д заасан гэрээ байгуулах хүсэлтийг хүлээн авч хянана.

4.2. Хүсэлтийг хянах явцдаа хөрөнгө оруулагч иргэн, хуулийн этгээдээс энэхүү зааврын 3.2-д зааснаас бусад шаардлагатай бичиг баримтыг нэмж авч болно.

4.3. Захирагч, түүний ажлын алба нь дор дурдсан үндэслэлээр гэрээ байгуулах, хэлэлцээ хийхээс татгалзаж болно:

4.3.1. Хуулийн этгээдийн аливаа үйл ажиллагаа, хөрөнгө оруулах үйл ажиллагааны шинж чанар нь Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд харшилсан;

4.3.2. хөрөнгө оруулах үйл ажиллагаа нь үр ашиггүй, салбарын бодлого, чөлөөт бүсийн төлөвлөлтөд сөрөг нөлөөлөл үзүүлэх бол;

4.3.3. хөрөнгө оруулах аливаа үйл ажиллагаа, төсөл, хөтөлбөр нь байгаль орчинд их хэмжээний хохирол учруулахаар бол.

4.4. Захирагч, түүний ажлын алба нь энэхүү зааврын 4.3-д заасан нөхцөл үүссэн эсэхийг нягтлах явцдаа холбогдох байгууллагын санал, дүгнэлтийг авна.

4.5. Энэхүү зааврын 4.3-д заасан гэрээ байгуулах хэлэлцээ хийхээс татгалзах үндэслэл тогтоогдсон бол Захирагч, түүний ажлын алба хүсэлт гаргагч иргэн, хуулийн этгээдэд бичгээр хариу өгнө.

4.6. Захирагч, түүний ажлын алба нь хуулийн этгээдээс гэрээ байгуулах албан хүсэлтийг авснаас хойш ажлын 30 хоногийн дотор гэрээний нөхцөлийг хэлэлцэн тохиролцож гэрээ байгуулна.

4.7. Гэрээний хугацааг хуулийн этгээдтэй зөвшилцэн тодорхойлж гэрээнд тусгах үүрэг хүлээнэ.

Тав. Гэрээ байгуулах

5.1. Энэхүү зааврын 4.3-т заасан татгалзах үндэслэл тогтоогдоогүй нөхцөлд чөлөөт бүсийн Захирагч, түүний ажлын алба нь хүсэлт гаргагч хуулийн этгээд,

иргэнийг гэрээ байгуулах хэлэлцээнд урина.

5.2. Захирагч, түүний ажлын алба нь хүсэлт гаргагч хуулийн этгээдтэй гэрээ байгуулах хэлэлцээг хийх ажлын хэсгийг шаардлагатай гэж үзвэл байгуулна.

5.3. Захирагч, түүний ажлын алба нь гэрээ хийх явцдаа мэргэжлийн эрдэмтэн, шинжээчдээс бүрдсэн хөндлөнгийн зөвлөх үйлчилгээг авч болно.

5.4. Талууд гэрээний төслийг хэлэлцээний үр дүнд харилцан бүрэн тохиролцсоны дараа ажлын хэсэг чөлөөт бусийн Захирагчид танилцуулж гэрээг байгуулна.

Зургаа. Гэрээний агуулга

6.1. Гэрээг бичгээр монгол хэл дээр байгуулах бөгөөд хамтран ажиллах гэрээнд доор дурдсан зүйлийг тусгана.

-гэрээ байгуулсан хууль, эрх зүйн үндэслэл;

-иргэн, хуулийн этгээд нь хөрөнгө оруулах үйл ажиллагааны төслийг хуулийн этгээдийн нэгдэл, түншлэлийн бүтэцтэйгээр эсхүл харилцан хамаарал бүхий хуулийн этгээдийн хамт хэрэгжүүлэх бол гэрээний зохицуулалтад хамаарах хуулийн этгээдийн оноосон нэр, улсын бүртгэлийн болон татвартөлөгчийн гэрчилгээний дугаар;

-төслийн зорилго, үндсэн үйл ажиллагаа;

-төсөлд зарцуулах хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр;

-төслийн хугацаа, үе шат;

-гэрээний хугацаа;

-хөдөлмөрийн харилцааны талаарх хууль тогтоомжийг мөрдөх, шинэ ажлын байр бий болгох, боловсон хүчнийг бэлтгэх тухай;

-Захирагчийн ажлын албаны эрх, хүлээх үүрэг;

-төсөл хэрэгжүүлэх иргэн, хуулийн этгээдийн эрх, хүлээх үүрэг;

-гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах үндэслэл;

-гэрээг хүчингүй болгох, гэрээ дуусгавар болох үндэслэл;

-маргаан шийдвэрлэх;

-талууд гэрээний хэрэгжилтэд хэрхэн хяналт тавих;

-талууд харилцан тохиролцсон бусад нөхцөлүүд.

6.2. Гэрээг хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хууль тогтоомжуудад нийцүүлэн байгуулна.

Долоо. Гэрээний хэрэгжилтэд хяналт тавих, дүгнэх

7.1. Гэрээ байгуулсан хөрөнгө оруулагч иргэн, хуулийн этгээд нь Чөлөөт бусийн тухай хууль болон хамтран ажиллах гэрээнд заасны дагуу хөрөнгө оруулах үйл ажиллагаа, төслийн хэрэгжилтийн талаарх тайлангаа дараа жилийн 1 дүгээр улиралд багтаан чөлөөт бусийн Захирагч, түүний ажлын албанд гаргаж өгөх үүрэгтэй.

7.2. Чөлөөт бүсийн Захирагч, түүний ажлын алба нь гэрээний хэрэгжилтийн тайланг хөрөнгө оруулагчаас авснаас хойш 30 хоногийн дотор хуулийн этгээдтэй хамтран дүгнэнэ.

7.3. Гэрээний хэрэгжилтэд чөлөөт бүсийн Захирагч, түүний ажлын алба хяналт тавих бөгөөд шаардлагатай тохиолдолд салбарын болон бусад холбогдох байгууллагуудтай хамтран ажиллаж болно.

7.4. Иргэн, хуулийн этгээд гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй тохиолдолд гэрээг цуцлах эрх нь Захирагчийн Ажлын албанад байна.

7.5. Хөрөнгө оруулалтын гэрээний харилцаанаас үүсэх маргааныг Монгол Улсын хууль болон тухайн гэрээнд заасны дагуу шийдвэрлэнэ.

Найм. Хариуцлага

8.1. Дараах тохиолдолд гэрээг цуцлах, дуусгавар болгох үндэслэл болно. Үүнд:

8.1.1. Хуулийн этгээд гэрээний биелэлтийг энэхүү зааврын 7.1-д заасан хугацаанд Захирагч, түүний ажлын албанад хүргүүлээгүй тохиолдолд гэрээг цуцлах үндэслэл болно;

8.1.2. Гэрээний хүчин төгөлдөр байх хугацаа дуусахаас өмнө гэрээлэгч талуудын аль нэг нь гэрээг гэрээнд заасан үндэслэлээр цуцлах хүсэлтээ бичгээр гаргасан бол гэрээг цуцлах үндэслэл бүрдэнэ;

8.1.3. Гэрээний хүчин төгөлдөр хугацаа дууссан, эсхүл гэрээг сунгах хүсэлт гаргаагүй тохиолдолд;

8.1.4. Талууд гэрээний хэрэгжилтийг хамтран дүгнэж акт үйлдсэнээр гэрээг дуусгавар болсонд тооцно.

---оОо---

"Замын-Үүд" чөлөөт бүсийн Захирагчийн
2025 оны ... дугаар сарын ... -ны өдрийн
A/13 тоот захирамжийн 2 дүгээр хавсралт

УХА0373

Санк. № 53-111510-07700

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ГЭРЭЭНИЙ ЗАГВАР

ГЭРЭЭ №ХО-202Х...../...../

Чөлөөт бүсийн тухай, Газрын тухай, Барилгын тухай болон бусад холбогдох хууль тогтоомжийг үндэслэн чөлөөт бүсэд хөрөнгө оруулах аж ахуйн нэгж байгууллага, хуулийн этгээдийн хөрөнгө оруулалтын үе шат, хэмжээ, төсөл хэрэгжүүлэх хугацаа, гэрээ байгуулагч талуудын эрх, үүрэг, хүлээх хариуцлагыг харилцан тохиролцож энэхүү **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ГЭРЭЭ**-г (цаашид "Гэрээ" 20... оны дугаар сарын-ны өдөр

НЭГ ТАЛААС:

Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, Ж.Самбуу 11, Засгийн газрын 11-р байр, 11 давхар, 1101 тоот,

Шуудангийн хайрцаг: 38/147

Утасны дугаар: 976-51-260143

Факс: 976-51-318168

Цахим хаяг: zfz.gov.mn

Вэбсайт: info@zfz.gov.mn

"Замын-Үүд" чөлөөт бүсийн Захирагчийн Ажлын алба (цаашид "Ажлын алба" гэх);

НӨГӨӨ ТАЛААС:

Улаанбаатар хот, дүүрэг,дугаар хороо, гудамж,байранд байрлах албан байртай, аж ахуйн нэгжийн тоот гэрчилгээ, регистрийн дугаартай,

Шуудангийн хайрцаг:

Утасны дугаар:

Факс:

Цахим хаяг:

Вэбсайт:

Монгол Улсын холбогдох хуулийн дагуу зохих ёсоор үүсгэн байгуулагдан, үйл ажиллагаагаа явуулж буй /Чөлөөт бүсэд бүртгэлтэй Иргэн, ААН-ийн нэрийг бичих/ хязгаарлагдмал хариуцлагатай компани, (цаашид “Хөрөнгө оруулагч” гэх) нар;

“Замын-Үүд” чөлөөт бүсийн Захирагчийн Ажлын алба болон ХХК /Чөлөөт бүсэд бүртгэлтэй ААН-ийн нэрийг бичих/ нь (хамтад нь цаашид “Талууд” гэх ба тус тусад нь “Тал” гэнэ) энэхүү гэрээний нөхцөл, өөрт нь олгогдох эрх, хүлээх үүрэг хариуцлагыг хүлээн зөвшөөрч дор дурдсан нөхцөлтэйгөөр БАЙГУУЛАВ.

ГЭРЭЭГ БАЙГУУЛАХДАА:

“Замын-Үүд” чөлөөт бүсийн Захирагчийн Ажлын албанаас зарласан төсөл сонгон шалгаруулалтад “.....” /Төсөл сонгон шалгаруулалт, Дуудлага худалдаанд орсон ААН-ийн нэрийг бичих/ ХХК-ний төсөл шалгарсныг тэмдэглэн,

“.....” ХХК /Чөлөөт бүсэд бүртгэлтэй ААН-ийн нэрийг бичих/ нь “Замын-Үүд” чөлөөт бүсэд үйл ажиллагаа явуулахаар хуулийн этгээдийн бүртгэл хийлгэснийг тэмдэглэн,

“Замын-Үүд” чөлөөт бүсийн Захирагчийн Ажлын албанаас “.....” ХХК-д /Чөлөөт бүсэд бүртгэлтэй ААН-ийн нэрийг бичих/ 20... оны.....дугаар сарын-ны өдрийн А/.... дугаар захирамжаар газар ашиглуулах болсныг тэмдэглэн,

..... ХХК нь /Чөлөөт бүсэд бүртгэлтэй ААН-ийн нэрийг бичих/ Гэрээ байгуулагдсан өдрөөс эхлэн бүх үйл ажиллагаа, үйлдвэрлэл, үйлчилгээ эхлэхийн өмнөх болон төсөл бүрэн хүчин чадлаараа хэрэгжиж эхлэх хүртэлх үе шатны ажлыг санхүүжүүлэх болохыг тэмдэглэн,

ИЙМД, энэхүү гэрээнд заасан харилцан тохиролцоо болон хэлцлийн хүрээнд Гэрээнд заасан нөхцөл, болзлыг үндэслэн, Талууд үүгээр дараах зүйл, заалтуудыг харилцан тохиролцов.

НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

1.1. “Замын-Үүд” чөлөөт бүсэд хийгдэх хөрөнгө оруулалтын үе шат, хэмжээ, түүнийг хэрэгжүүлэх хугацаа, оролцогч талуудын эрх үүрэг, хүлээх хариуцлагыг харилцан тохиролцож энэхүү гэрээг байгуулав.

1.2. Энэхүү гэрээгээр зохицуулагдаагүй аливаа эрх зүйн харилцааг Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөж буй хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэнэ.

1.3. Энэхүү гэрээг байгуулснаар өмнө байгуулсан хөрөнгө оруулалтын гэрээ хүчингүй болно.

1.4.

ХОЁР. НЭР ТОМЬЁОНЫ ТОДОРХОЙЛОЛТ

Энэхүү Гэрээнд хэрэглэсэн дараах нэр томьёог дор дурдсан утгаар ойлгоно:

2.1. "Хамааралтай этгээд" гэж Гэрээний Талыг шууд болон шууд бусаар хянаж байгаа буюу түүнд хянагдаж байгаа бөгөөд түүний хяналтын дор байгаа аливаа этгээд, компани, байгууллагыг. Энд хэрэглэгдэж буй хяналт (хянаж, хянагдаж, хяналтын дор байгаа гэсэн утгуудыг багтааснаар) гэдэг нь эрх олгосон бусад хэлцлээр дамжуулж холбогдох этгээд, компани, байгууллагын удирдлага, бодлогод шууд болон шууд бусаар нөлөөлөх эрх мэдлийг ойлгоно;

2.2. "Эд хөрөнгө" гэж газар, уг газар дээр барих барилга байгууламж, үйлдвэр ба бүтээгдэхүүн, хувь нийлүүлсэн хөрөнгө болон Компанийн үйл ажиллагаанд хэрэглэгдэж буй биет болон биет бусад эд зүйлсийг;

2.3. "Үйлдвэрлэл, үйлчилгээ эхлэх өдөр" гэж хөрөнгө оруулалтаа оруулж, үйлдвэр, үйлчилгээний барилга байгууламжаа барьж эхэлсэн өдрийг;

2.4. "Зардал" гэж тоног төхөөрөмж худалдан авах, тээвэр гүйцэтгэх, ажилчдын шагнал урамшуулал, цалин, тэтгэмж, хоол хүнс, байрны зардлыг төлөх, ТЭЗҮ батлуулах зэргээр Компанийн үйл ажиллагаатай холбоотойгоор, зөвшөөрөгдсөн гэнэтийн зардлыг оруулан бэлэн мөнгө, өглөг зэрэг аливаа хэлбэрээр гаргасан зардал, өр төлбөрийн үүргийг;

2.5. "Газар" гэж "Замын-Үүд" чөлөөт бүсийн Захирагчийн захирамжаар Ажлын албанаас ашиглуулахаар олгосон газрыг;

2.6. "Төсөл" гэж үйлчилгээ, үйлдвэрлэлийн "Замын-Үүд" чөлөөт бүсэд хэрэгжүүлэх хөтөлбөрийг;

2.7. "Төлбөр" гэж Чөлөөт бүсийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.5-д заасан нэг удаагийн төлбөрийг, Газрын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1-д заасан газрын төлбөр болон холбогдох бусад төлбөрийг хэлнэ.

ГУРАВ. ГЭРЭЭНИЙ НӨХЦӨЛ

3.1. Гэрээ байгуулагдсан өдрөөс эхлэн бүх үйл ажиллагаа, үйлдвэрлэл, үйлчилгээ эхлэхийн өмнө болон төсөл бүрэн хүчин чадлаараа хэрэгжиж эхлэх хүртэлх үе шатны хөрөнгө оруулалтыг нэг жилийн хугацаанд хуваарийн дагуу хийж, бүтээн байгуулалтын үйл ажиллагаа эхлүүлээгүй, гэрээнд заасан хөрөнгө оруулалтын чиглэлээс өөр үйл ажиллагаа зөвшөөрөлгүй эрхэлсэн, Захирагчийн ажлын албанаас бичгээр тавьж буй хууль ёсны шаардлагыг нэг ба түүнээс дээш удаа үл биелүүлсэн, гэрээгээр хүлээсэн үүргээ зөрчсөн нөхцөл үүссэн тохиолдолд хөрөнгө оруулалтын гэрээ цуцлагдах бөгөөд өмнө төлөгдсөн бүх төрлийн төлбөрийг хөрөнгө оруулагчид буцаан олгохгүй.

3.2. Хөрөнгө оруулалтын гэрээ цуцлагдсан тохиолдолд газар ашиглуулах гэрээ хүчингүй болно.

3.3. Газар ашиглах гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүйн улмаас газар, ашиглах гэрээ цуцлагдсан тохиолдолд хөрөнгө оруулалтын гэрээ цуцлагдана.

3.4. Талууд гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг зөвхөн албан бичгээр шаардана. Хөрөнгө оруулагчийн хаяг, утас, и-мэйл өөрчлөгдсөн тохиолдолд Захирагчийн ажлын албанд мэдэгдээгүй бол Захирагчын ажлын албанаас хөрөнгө оруулагчын хуучин буюу бүртгэгдсэн хаяг руу явуулсан албан бичгийг албан ёсоор явсан гэж үзнэ. Энэ бичгийг хөрөнгө оруулагч хүлээж аваагүй нь албан ёсны шаардлага хүлээж аваагүй гэх үндэслэл болохгүй.

3.5. Хөрөнгө оруулагч нь гэрээний хугацаанд гэрээ байгуулагдсан өдрөөс эхлэн бүх үйл ажиллагаа, үйлдвэрлэл, үйлчилгээ эхлэхийн өмнөх болон төсөл бүрэн хүчин чадлаараа хэрэгжиж эхлэх хуртлэх үе шатны хөрөнгө оруулалтын ажлын хувиарийг гэрээний хавсралтаар Захирагчын ажлын албанд ирүүлнэ.

ДӨРӨВ. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛ

4.1. Хөрөнгө оруулалтын чиглэл нь үйл ажиллагаа болно.

4.2. Хөрөнгө оруулалтын дүн нь төгрөг /ам.доллар/ байна.

ТАВ. ГЭРЭЭНИЙ ХУГАЦАА

5.1. Хөрөнгө оруулалтын гэрээний хугацаа.....жил байна. Гэрээний хугацааг талууд гэрээнд гарын үсэг зурж баталгаажуулсан өдрөөс эхэлж тооцно.

5.2. Гэрээний хугацаа дуусахад гэрээний үүргээ зохих ёсоор биелүүлж, хөрөнгө оруулалтаа гэрээнд заасан хугацаа, хуваарийн дагуу хийж байгааг харгалзан талууд гэрээний хугацааг дахин сунгаж болно. Хөрөнгө оруулалтын гэрээг сунгах хүсэлтээ хөрөнгө оруулагч нь уг гэрээний хугацаа дуусахаас 30 хоногийн өмнө Захирагчийн Ажлын албанд бичгээр гаргана.

ЗУРГАА. ЗАХИРАГЧИЙН АЖЛЫН АЛБАНЫ ЭРХ, ҮҮРЭГ

6.1. Энэхүү гэрээнд тусгагдсан хөрөнгө оруулалтыг хэрэгжүүлэх үе шатны ажлуудыг цаг хугацаанд нь биелүүлэхийг хөрөнгө оруулагчаас шаардаж, тайлан, мэдээлэл гаргуулж, газар дээр нь нягтлан шалгана.

6.2. Захирагчийн ажлын алба нь албан хэрэгцээнд зориулан бусад төрийн байгууллагатай байгуулсан мэдээлэл солилцох гэрээний дагуу Хөрөнгө оруулагчийн мэдээллийг гаргуулан авах эрхтэй.

6.3. Бүсийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнд нийцүүлсэн газар зохион байгуулалтын байдал, талбайн ашиглалт, норм нормативын мөрдөлт болон аж ахуйн үйл ажиллагааны хэрэгжилтийн талаар мэдээ, тайлан гаргана.

6.4. Хөрөнгө оруулагчдад хууль тогтоомж, дүрэм журам, тэдгээрт орж буй өөрчлөлт, бүсийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний талаар дэлгэрэнгүй мэдээллийг өгч ажиллана.

6.5. Энэхүү гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг шаардаж, холбогдох эрх бүхий байгууллагад асуудал тавьж шийдвэрлүүлэх эрхтэй.

6.6. Хөрөнгө оруулалтын ажил саадгүй явагдах эрх зүйн орчныг бүрдүүлэх, холбогдох мэдээллээр хангах, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах.

6.7. Хуульд заасан төрийн бусад үйлчилгээг шуурхай үзүүлэх.

6.8. Хөрөнгө оруулалтын үйл ажиллагаанд хяналт тавих, гэрээгээр хүлээсэн үүргээ зохих ёсоор биелүүлэхийг хөрөнгө оруулагчаас шаардах.

ДОЛОО. ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧ ИРГЭН, ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ЭРХ, ҮҮРЭГ

7.1. Хөрөнгө оруулагч нь энэхүү Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх бөгөөд Монгол Улсын хууль тогтоомжийг дагаж мөрдөнө.

7.2. Хөрөнгө оруулагч нь Чөлөөт бүсийн тухай болон бусад холбогдох хуульд заасан татварын болон татварын бус хөнгөлөлт, чөлөөлөлт, дэмжлэгийг эдлэх.

7.3. Хөрөнгө оруулалтын энэхүү гэрээнд заагдсан барилга, байгууламжтай холбоотой барилгын ажлын зураг төсөл, техник эдийн засгийн үндэслэлийг Захирагчийн Ажлын албанаас тавьж буй шаардлагаас гадна дараах шаардлагыг зайлшгүй тусгасан байна. Үүнд:

а. Ажлын албанаас олгосон газарт тусгаарлах хашааг ногоон байгууламжаар шийдэх.

б. Хөгжлийн бэрхшээлтэй иргэд, бага насны хүүхэдтэй иргэд зорчих, үйлчлүүлэхэд ээлтэй орчин нөхцлийг бүрдүүлсэн байх.

7.4. Төслийн бэлтгэл ажлын үе шатанд үйлдвэрлэл, үйлчилгээ явуулахад шаардлагатай зөвшөөрлийг авсан байна.

7.5. Тус гэрээнд тусгагдсан хөрөнгө оруулалтыг ирүүлсэн хувиарийн дагуу тогтоосон хугацаанд, үе шаттайгаар оруулах.

7.6. Ажлын албанд хууль ёсны шаардлага тавих, хуульд заасан төрийн үйлчилгээг үзүүлэхийг шаардах. Ажлын албанаас бүсийн үйл ажиллагаатай холбоотой мэдээллийг авах, бүсийн Хөгжлийн ерөнхий төлөвлөгөөтэй танилцах.

7.7. Хөрөнгө оруулагч нь бусад төрийн байгууллагад бүртгүүлсэн мэдээллийг захирагчийн ажлын албанд ашиглуулах үүрэгтэй.

7.8. Хөрөнгө оруулагч нь хөрөнгө оруулалтын төслийг бусад хуулийн этгээдтэй гэрээний үндсэн дээр хамтран хэрэгжүүлж болох бөгөөд энэ тохиолдолд гэрээгээр хамтран ажиллах хуулийн этгээд нь хуульд заасны дагуу бүртгүүлж, гэрчилгээ авах үүрэгтэй байна.

7.9. Хөрөнгө оруулагчийн албан ёсны хаяг, байршил, харилцах утас, факс өөрчлөгдсөн тохиолдолд ажлын 10 хоногийн дотор Ажлын албанд бичгээр мэдэгдэнэ.

7.10. Хөрөнгө оруулагч нь тухайн нэгж талбайд Монгол Улсад үйл ажиллагаа явуулах зөвшөөрөлтөй харуул хамгаалалтын байгууллагаар хамгаалалтын үйл ажиллагааг зохион байгуулах, хяналтын камержуулалт сууринуулсан байх.

7.11. Хөрөнгө оруулагч нь хөрөнгө оруулалтын төсөл /хөдлөх, үл хөдлөх/-ийг барьцаалах замаар банкнаас зээлийн санхүүжилт авч төслийг хэрэгжүүлэх эрхтэй. Энэ нөхцөлд Хөрөнгө оруулагч нь захирагчийн ажлын албанаас зөвшөөрөл авах шаардлагагүй бөгөөд мэдэгдэх үүрэгтэй.

7.12. Чөлөөт бүсэд бүртгэлтэй аж ахуйн нэгж нь нийгмийн хариуцлагын хүрээнд агаарын бохирдол, орчны тоосжилтоос сэргийлж, чөлөөт бүсийн нутаг дэвсгэрт нийтийн эзэмшлийн зам талбайн хүрээлэн буй орчныг сайжруулах үүднээс ногоон байгууламж, мод, бут, сөөгийг тарьж ургуулахад дэмжлэг үзүүлнэ.

7.13. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн хэрэгжилтийг хангах, аюулгүй байдал, стандартыг мөрдөх, хагас жил бүр Захирагчийн ажлын албанд ирүүлэх.

7.14. Хуульд заасан бусад эрх үүрэг.

НАЙМ. ХАРИУЦЛАГА

8.1. Хөрөнгө оруулалтын гэрээ нь хөрөнгө оруулагчийн буруутай үйлдлийн улмаас цуцлагдсан тохиолдолд энэхүү гэрээний 2 дугаар зүйлийн 2.7-д заагдсан төлбөрийг хөрөнгө оруулагчид буцаан олгохгүй.

8.2. Дараах тохиолдолд хөрөнгө оруулалтын гэрээг хугацаанаас үл хамааран цуцлана. Үүнд:

8.2.1. Хөрөнгө оруулагч хуулийн этгээд Гэрээ байгуулснаас хойш 1 жилийн хугацаа өнгөрсөн буюу 20... оны ... дугаар сарын.. -ний өдөр хүртэл гэрээнд заасан үндсэн үйлдвэрлэл үйлчилгээг эхлүүлээгүй бол.

8.2.2. Үйл ажиллагаагаа эхлүүлсэн боловч 1 жилээс дээш хугацаагаар үйл ажиллагаа нь өөрөөс хамаарах шалтгаанаар тасалдсан, зогссон.

8.2.3. Хууль тогтоомж болон гэрээгээр хүлээсэн үүргээ зөрчсөн.

ЕС. ГЭРЭЭ ДУУСГАВАР БОЛОХ

9.1. Энэхүү Гэрээний 5 дугаар зүйлийн 5.1 болон 5.2-т заасан хүчинтэй хугацаа дууссаны дараа хөрөнгө оруулагч нь гэрээний хугацааг сунгах хүсэлт гараагүй бол,

9.2. Хөрөнгө оруулагч нь энэхүү Гэрээний эрхийг бусад аж ахуйн нэгж байгууллага, хуулийн этгээдэд шилжүүлсэн бол,

9.3. Хөрөнгө оруулагчын төсөл хэрэгжиж барилга байгууламжийг ашиглалтанд хүлээн авсан улсын комиссын дүгнэлт гарсанаар энэхүү гэрээ дуусгавар болно.

АРАВ. МАРГААН ШИЙДВЭРЛЭХ

10.1. Энэхүү гэрээнээс үүссэн болон холбогдон гарсан түүнчлэн уг гэрээг хэрэглэх, тайлбарлах, хүчинтэй хугацааг тогтоох, сунгах, цуцлахтай холбогдсон аливаа маргааныг талууд эвийн журмаар зөвшилцэн шийдвэрлэх ба зөвшилцэлд хүрээгүй тохиолдолд шаардах эрх бүхий тал харьялагдах шатны шүүхээр шийдвэрлүүлнэ.

10.2. Энэхүү гэрээнд зааснаас бусад асуудлаар үүдэн гарсан маргааныг Монгол Улсын холбогдох, хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэнэ.

АРВАН НЭГ. БУСАД ЗҮЙЛ

11.1. Хөрөнгө оруулалтын гэрээг тухайн оны эцэст дүгнэж, ажлын явцын талаар ярилцаж протокол хөтлөнө.

11.2. Дэд бүтцийн бүтээн байгуулалтын ажил, инженерийн шугам сүлжээ баригдаж дуусаагүй нь гэрээний хугацааг тасалдуулах, түүний нарийвчилсан хугацаа, үе шат, графикийг хойшлуулах үндэслэл болохгүй бөгөөд төслийн бүтээн байгуулалтын үед хөрөнгө оруулагч дэд бүтцийг /дулаан, цахилгаан, усан хангамж, г.м/ тухайн үеийн нөхцөлд тааруулан шийдвэрлэх.

11.3. Энэхүү гэрээний оролцогч талууд гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулж болох бөгөөд эдгээр нэмэлт өөрчлөлт нь гэрээний салшгүй хэсэг болно.

14.4. Талуудын баталсан хавсралтыг гэрээний нэг хэсэг гэж үзнэ. Хавсралтыг гэрээний хамгийн арын хуудсанд хавсаргана.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН :

ИЙНХҮҮ ТУС ГЭРЭЭНД ДУРДСАНЫГ БАТАЛГААЖУУЛАН, Талууд энэхүү Гэрээг тэдгээрийн холбогдох эрх бүхий албан тушаалтан хоёр эх хувь гэрээний эхэнд бичигдсэн огноогоор байгуулав.

“Замын-Үүд” чөлөөт бүсийг төлөөлж: ХХК-ийг төлөөлж:

ЗАХИРАГЧИЙН АЖЛЫН АЛБАНЫ
ДАРГА

ЗАХИРАЛ